


“Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны үйл ажиллагааны бичмэл тайлан” Хавсралт-1

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ФОТО ЗУРАГ



2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авлаа.



Гадаад паспортын зургийн өрөөг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тохижуулав.

**“Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
2023 оны үйл ажиллагааны бичмэл тайлан” Хавсралт-1**



Хэлтсийн албан хаагчдад сар бүр онлайнаар хурал зохион байгуулж цаг үеийн байдал, болон тулгамдаж буй асуудал, УБЕГ болон Аймаг орон нутгийн удирдлага, өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр танилцуулан ажиллаж байна.



2023 оны 3 дугаар сарын 05-ны өдөр тус хэлтэст гэрээт жолоочоор ажиллаж байсан Д.Гансүх, гэрээт үйлчлэгч Б.Отгончимэг нарт хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулав

**“Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
2023 оны үйл ажиллагааны бичмэл тайлан” Хавсралт-1**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөн болон “Үндэсний мод тарих өдөр”-ийн хүрээнд 2023.05.13-ны өдөр Хэлтсийн албан хаагчид Шүтээний өндөрлөгийн баруун талд 100 ш хайлаас, 2023.10.13-ны өдөр хэлтсийн гадна талд 9 ш шар хуайсыг тус тус тарилаа.



Ерөнхий боловсролын 12 жилийн 1,2,3 дугаар сургуулийн ахлах ангийнханд мэдээлэл өгч ТАНИН МЭДЭХҮЙН “АХА” тэмцээнийг зохион байгуулж, бэлэг дурсгалын зүйлээр урамшууллаа



2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П. Сайнзоригоор ахлуулсан ажлын хэсэг ажиллав.

**“Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
2023 оны үйл ажиллагааны бичмэл тайлан” Хавсралт-1**



Ганболдын Энхням, Ганзоригийн Мөнгөнтуяа, Мөнхбаатарын Адьяасүрэн, Ганпүрэвийн Отгонсүрэн нарын залуу хосуудын гэрлэх ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.



Хяналтын улсын байцаагч, ЭХЭУБТасгийн дарга нараар ахлуулсан ажлын хэсэг Бугат, Төгрөг, Шарга, Тонхил, Дарив, Жаргалан, Баян-Уул сумдад томилолтоор ажиллалаа.

“Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
2023 оны үйл ажиллагааны бичмэл тайлан” Хавсралт-1



Е-MONGOLIA сайтад орсон улсын бүртгэлийн үйлчилгээнүүд болон Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, тоон гарын үсгийн ач холбогдлыг иргэдэд таниулах зорилгоор Мэдээлэл технологийн ажилтан Э.Баатарсүрэн Аймгийн Засаг Даргын ажлын хэсэгт орж Тайшир, Дэлгэр, Эрдэнэ, Чандмань, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Төгрөг, Бугат, Халиун, Цээл, Цогт сумдад 2023.10 сарын 01-ний өдрүүдэд ажиллаж 19000 гаруй иргэнд мэдээлэл, сурталчилгаа хийлээ.



**“Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
2023 оны үйл ажиллагааны бичмэл тайлан” Хавсралт-1**



2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр Хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Тайшир суманд ажиллаж бүртгэлийн цахим үйл ажиллагааг сурталчилж, иргэн эд хөрөнгийн бүртгэл хийлээ.




2023 оны 1,2,3 дугаар улиралд Аймгийн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны ерөнхий шалгалтад орж байгаа иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу хурууны хээний бүртгэлийг хийж хамтран ажилласан.

**“Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
2023 оны үйл ажиллагааны бичмэл тайлан” Хавсралт-1**



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн ой, Бүртгэлийн ажилтны баяр-2023 арга хэмжээний хүрээнд тус хэлтсийн баг тамирчид амжилттай оролцлоо.



83 жилийн ой, Бүртгэлийн ажилтны баяр-2023 арга хэмжээнд нийт албан хаагчдад Удирдлагын академийн багш доктор, профессор Т.Алтанцэцэгээр “Хувь хүний ёс зүй, харилцаа” сэдвээр 2 цаг, УБЕГ-ын Нэгдсэн архивын газрын мэргэжилтэн Дуламсүрэн 2 цагийн онлайн сургалтыг зохион байгууллаа.

**“Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн
2023 оны үйл ажиллагааны бичмэл тайлан” Хавсралт-1**



**83 жилийн ой, Бүртгэлийн ажилтны баяр-2023 арга хэмжээнд нийт албан
хаагчдын дунд спортын уралдаан зохион байгууллаа.**